

ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2025–2030 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1. Үндэслэл

Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичиг нь 2025–2030 оны хугацаанд хэрэгжих хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлж, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх, шинэ төвүүдийн хүний нөөцийн хэрэгцээг хангах, залуу мэргэжилтнүүдийг дэмжих, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулахад чиглэнэ

2. Зорилго

Эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, шинэ төвүүдийн хүний нөөцийг бүрдүүлэх.

3. Зорилт

1. Хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх
2. Шинэ төвүүдийн хүний нөөцийн хэрэгцээг бүрдүүлэх
3. Сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх

4. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн 161 байгууллагад 2089 эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаагаас 22.7 хувийг эмч, 24.5 хувийг сувилагч, тусгай дунд мэргэжилтэн эзэлж байна. Үүний 10.5 хувь нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд, 25.1 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 27.2 хувь нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад, 5.3 хувь нь Эрдэнэт сувиллын цогцолборт, 21.1 хувь нь эм ханган нийлүүлэх, эмийн сан, шүдний эмнэлэг, ариутгал халдваргүйтгэл зэрэг бусад байгууллагад ажиллаж байна.

10,000 хүн амд ноогдох их эмчийн тоо 45, сувилагч, тусгай дунд мэргэжилтний тоо 48.6 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байгаа хэдий ч эмч сувилагчийн харьцаа 1:1.1 байгаа нь сувилагч мэргэжлийн хэрэгцээ шаардлага үүсэж байгааг харуулж байна. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах зорилготой “Эмч” хөтөлбөрийг өнгөрсөн онуудад 3 зорилт 23-н арга хэмжээг 98.6 хувийн гүйцэтгэлтэй 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн үр дүнд 8 сувилагч сувилахуйн шаталсан бакалавр, 6

эмч магистр, 5 эмч анагаах ухааны докторын зэрэг хамгаалж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээг нэвтрүүлсэн. Мөн Эрүүл мэндийн салбарын 2023-2024 оны богино хугацааны төлөвлөлтийн 5 арга хэмжээг 89,5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Цаашид эрүүл мэндийн салбарт Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийг байгуулахаар төлөвлөөд байна.

Насны бүтэц:

29 хүртэлх нас: 20%
30–39 нас: 35%
40–49 нас: 25%
50–59 нас: 15%
60-аас дээш нас: 5%.

5. Ирээдүйн хэрэгцээний тооцоо

2025–2030 онд хүний нөөцийн хэрэгцээний өсөлт:

Эмч: +26 хүн (2025 онд 474 → 2030 онд 500)

Сувилагч: +89 хүн (2025 онд 511 → 2030 онд 600)

Эмнэлгийн мэргэжилтэн: +56 хүн (2025 онд 1104 → 2030 онд 1160)

6. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
- Туршлагатай эмч, сувилагч олон.	- Сувилагчийн хангалт муу.
- Оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж харьцангуй сайн.	- Ахмад ажилтнаас ажилтнаас хамааралтай болж хүний нөөцийн хомсдол үүсч байна.
- Улсын болон орон нутгийн төсвөөс сурах боломжтой.	- Улаанбаатар хот болон бусад орон нутагруу урт хугацаагаар сурах хүсэлгүй
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад болон дотоодын сургалтад хамруулж, чадавхыг нэмэгдүүлэх боломж сайн	- Сургаж, мэргэшүүлсэн хүний нөөцөө тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг муу
- Шинэ дэвшилтэт технологи, аргыг нутагшуулж байна.	- Цалин хангамж, урамшууллын тогтолцоо сул.
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дэргэд сургалтын албатай /төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, сувилахуйн төрөлжсөн мэргэшил олгох/	- Байгууллагууд орон нутагтаа суралцахад дэмжлэг муу, ажлын цагийн уян хатан бодлогогүй.
- Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдсан, нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах төсөл хэрэгжиж эхлэж байгаа.	- Бэлтгэгдсэн нийгмийн эрүүл мэндийн ажилтан бага

Боломж	Эрсдэл
Шинэ төвүүд нээгдэж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажлын байр бий болно	Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их

Гадаад, дотоод сургалтын хөтөлбөрүүд нэмэгдэнэ	Санхүүгийн тогтворгүй байдал
--	------------------------------

Санхүүгийн тогтворгүй байдал

7. Хавдрын төвийн хүний нөөцийн төлөвлөлт

Эрдэнэт Медикал эмнэлгийг түшиглэн байгуулах Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт, сэргийлэлтийн төвд шаардлагатай хүний нөөц судалгаа

№	Үндсэн мэргэшлийн чиглэл	Ажиллавал зохиx	Ажиллаж байгаа	Дутагдалтай байгаа
Үндсэн мэргэшил				
1	Хавдар судлалын эмч	3	3	
Төрөлжсөн мэргэшил				
2	Хавдрын хими эмчилгээ судлалын эмч	1	1	
3	Хавдрын туяа эмчилгээ судлалын эмч	1	-	1
4	Хөнгөвчлөх эмчилгээ судлалын эмч	1	1	
5	Эмэгтэйчүүдийн хавдар судлалын эмч			1
6	Хавдрын сувилагч			1
7	Хөнгөвчлөх эмчилгээний сувилагч	4	3	1
8	Эс судлал /биоанагаахын мэргэжилтэн/	1	1	
Мэргэжил дээшлүүлэх сургалт				
9	Бүдүүн шулуун гэдэсний хавдрын мэс засал судлал	1	-	1
10	Нойр булчирхайн хавдрын мэс засал судлал	1	1	
11	Ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал	1		Суралцаж байгаа 1
12	Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал	1		Суралцаж байгаа 1
13	Уушги, голтын хавдрын мэс засал судлал	1	-	1
14	Элэг цэсний хавдрын мэс засал	1	1	
15	Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал	1		Суралцаж байгаа 1
16	Умайн хүзүүний эс зүй судлал /3 сар/	1	-	1
17	Хавдрын хими эмчилгээний найруулга зүйд хамрагдсан эм зүйч /1 сар/	1	1	
18	Хавдрын хими эмчилгээний найруулга зүйд хамрагдсан эм найруулагч /1 сар/	1	1	

8. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмж их нэгж	Суурь түвшин /2024/	Хүрэх түвшин				Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж
				2025	2026	2027	2028		
Арга хэмжээ 1. Хүний нөөцийг сургах, хөгжүүлэх									

1	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	хувь	72.4%	73%	75%	78%	80%	эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний сургалтад хамрагдсан хувь	Жилд хоёр удаа
2	Эмч, сувилагчийн харьцаа	Тоо	1:1.1	1:1.5	1:1.5	1:1.8	1:2	1 эмчид ногдох сувилагчийн тоо	Жилд нэг удаа
3	Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг сайжруулж, нэн шаардлагатай мэргэжлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургах, гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг ур чадварыг дээшлүүлэх дээшлүүлэхэд туршлага судлах, сургалт хамруулах	Хувь	47,8	48%	48,5%	49%	49,5%	Нэн шаардлагатай мэргэжилээр сурсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Жилд хоёр удаа
4	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажиллангаа суралцан, мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн сургалтуудад хамруулах	Тоо	1400	1450	1500	1550	1600	Мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтан	Жилд хоёр удаа
5	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараахь сургалтын чадавхийг бэхжүүлж, эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга	Тоо	11	16	18	20	22	Төгсөлтийн дараахь сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Жилд хоёр удаа

	хэмжээг хамтран хэрэгжүүлэх								
6	Шинэ сувилагчийг дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тоо	13	15	16	17	18	Дадлагажсан сувилагчийн тоо	Жилд нэг удаа
Арга хэмжээ 2. Нийгмийн баталгааг хангах									
1	Үр бүтээлтэй ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг шагнаж урамшуулах	Хувь	10,5%	10,5%	10,5%	10,5%	10,5%	Шагнал урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь	Жилд хоёр удаа
2	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах	Тоо	5	6	6	7	7	Зохион байгуулагдсан уралдаан тэмцээний тоо	Жилд хоёр удаа

9. Хяналт, үнэлгээ

Хүний нөөцийн төлөвлөлтийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ үнэлгээг жилд нэг удаа Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэст тайлагнана. 2027, 2030 онд дунд хугацааны болон эцсийн үнэлгээ хийнэ.

10. Дүгнэлт

Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт нь 2025–2030 онд мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг шаардлагад нийцүүлэн хангаж, шинэ төвүүдийн үйл ажиллагааг амжилттай эхлүүлэх, салбарын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах баримт бичиг болно.